



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭРЭН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Шанд 2-200, Дэрэн сум, Дундговь аймаг, 48080,
Утас: 7505 8787, Цахим шуудан: dundgovideren1@gmail.com,
Цахим хуудас: Дэрэн сумын Засаг даргын тамгын газар

2025.03.19 № 02/25

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН ТӨРИЙН ЗАХИРГАА
УДИРДЛАГЫН ХЭЛТЭСТ

Тус сум нь “Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтад гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай” Монгол улсын хууль, “Иргэдийн санал өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 67 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар амаар, бичгээр биечлэн уулзсан 14 өргөдөл, санал хүсэлтийг хүлээн авч бүртгэсэн. 15 хоногийн хугацаанд ӨГСХ-ийг шийдвэрлэж шийдвэрлэлт 100 % байна.

ДАРГА

Г.ЗУЛБААТАР



482506960

2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ДЭРЭН СУМЫН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН
ТУШААЛТАД ХАНДАЖ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТУХАЙ


2025.03.19


Цант

Дэрэн сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, байгууллага, багуудад хандан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэхдээ холбогдох албан тушаалтнууд "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтад гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай", Монгол улсын хууль, Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай", Засгийн газрын 67 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон амаар, бичгээр, биечлэн, утсаар хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг амаар болон бичгээр эргэн мэдэгдэж ажиллаж ирлээ.

2025 оны 1 дүгээр улиралд иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтад хандаж амаар бичгээр 14 ӨГСХ ирсэн. 15 хоногийн хугацаанд шийдвэрлэсэн.

Аймгийн "Оюунлаг Дундговь" дэд хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн захирал захирал Д.Мөнхтогтох нь Боловсролын газар, Мэхсим ХХК-ны хамтын ажиллагааны гэрээний дагуу Өмнөд Солонгос улсад туршлага судлах болсон сум дэмжлэг үзүүлж "Хүний нөөцийг дэмжих" дэд хөтөлбөрөөс 1,500,000 зардал гаргахаар хүсэлтийг шийдвэрлэсэн.

ТАНИЛЦУУЛГА ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА  Г.ЗУЛБААТАР

ТАНИЛЦУУЛГА ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
АЖИЛТАН  Б.ЦЭЦЭГСҮРЭН

ДЭРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Дугаар 03

2025.03.17.

Цант

Хурлыг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 16⁰⁰ цагт эхэлж хуралдаанд Сумын Засаг дарга Д.Жамбалрагчаа, Зөвлөлийн гишүүд Засаг даргын орлогч Н.Мядагмаа, ЗДТГ-ын дарга Г.Зулбаатар, Санхүү албаны дарга С.Цэрэнрагчаа, Төрийн сангийн мэргэжилтэн С.Мөнхтуяа нар оролцов. Хурлыг Засаг дарга удирдан зохион байгуулсан.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1.Аймгийн “Оюунлаг Дундговь” дэд хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Мөнхтогтох нь Боловсролын газар, Мэксим ХХК-ны хамтрын ажиллагааны гэрээний Өмнөд Солонгос улсад туршлага судлах болсон тул сумаас дэмжлэг туслалцаа хүссэн хүсэлт өгсөн.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

- Д.Жамбалрагчаа (Засаг дарга)

-Аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01/79 дугаар албан бичгийн дагуу “Оюунлаг Дундговь” хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Мөнхтогтох туршлага судлахад сумаас дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна.

СОНССОН НЬ:

-Г.Зулбаатар (Засаг даргын Тамгын газрын дарга)

-Захирлын хүсэлтийн дагуу хөрөнгө мөнгөний дэмжлэг боломжоороо үзүүлье.

Засаг даргын нөөц “Хүний нөөцийг дэмжих” дэд хөтөлбөрөөс зардал гаргах.

СОНССОН НЬ:

Н.Мядагмаа (Засаг даргын орлогч)

-Боломжоороо дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Сумын Засаг даргын захирамжаар дэмжлэг үзүүлэхээр боллоо.

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА Д.ЖАМБАЛРАГЧАА

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
АЖИЛТАН Б.ЦЭЦЭГСҮРЭН



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/52

Цант

Д.Мөнхтогтоход дэмжлэг
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.6 дахь заалт, сумын “Хүний нөөцийг дэмжих” дэд хөтөлбөрийн 3.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн “Оюунлаг Дундговь” дэд хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн захирал Дадьсүрэнгийн Мөнхтогтох нь Боловсролын газар, Мэксим ХХК-ны хамтын ажиллагааны гэрээний дагуу Өмнөд Солонгос улсад туршлага судлах болсон тул 1,500,000 (нэг сая таван зуун мянган) төгрөгийн дэмжлэгийг сумын “Хүний нөөцийг дэмжих” дэд хөтөлбөрөөс гаргасугай.

2.Дээрх зардлыг зохих журмын дагуу гаргаж хяналт тавьж, холбогдох бичиг баримтыг бүрдүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Зулбаатар), нягтлан бодогч (Э.Эрхтогтос)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ЖАМБАЛРАГЧАА

482501167